**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 04 өдөр Дугаар А/163 Арвайхээр сум

Мөрдөстэй бүсгүйчүүд анхдугаар чуулга уулзалт
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.1.20, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.1.5, 3.3.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны ой, Эх орончдын өдөр, Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан орон нутгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, ажиллаж байгаа эмэгтэй алба хаагчдын нийгмийн идэвхийг нэмэгдүүлэх, сэтгэл зүйг дэмжих, тулгамдаж буй асуудлыг хэлэлцэх мөрдөстэй бүсгүйчүүд анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулж, зардалыг хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд зарцуулах 3,990,000, (гурван сая есөн зуун ерэн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Арвайхээр цэргийн хүрээний мөрдөстэй бүсгүйчүүд анхдугаар чуулга уулзалт зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөг гарган, хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Сумъяасүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА И.ДОРЖСҮРЭН

G224 II 0344

D:My Doc. Zahirami. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар
сарын 01 -ны өдрийн А/163 дугаар
захирамжийн хавсралт

## МӨРДӨСТЭЙ БҮСГҮЙЧҮҮД АНХДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

| Д/д | Эд материал | Хэрэглэгдэхүүн | Хэмжих нэгж | Нэг бүрийн үнэ | Нийт хэрэгтэй | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Анонс | Чуулга уулзалтыг илэрхийлэх | 1м² | 25,000 | 12м² | 300,000 |
| 2 | Хөлтэй самбар (хулдаас) | | 1м² | 72,000 | 2 | 144,000 |
| 3 | Хөлтэй самбар (хөл) | | Ширхэг | 25,000 | 2 | 50,000 |
| 4 | Энгэрийн тэмдэг | | Ширхэг | 1600 | 70 | 112,000 |
| 5 | Дэвтэр | Сургалтын хэрэглэгдэхүүн | Ширхэг | 12,000 | 70 | 840,000 |
| 6 | Бал | | Ширхэг | 2500 | 70 | 175,000 |
| 7 | Кофе | Цайны завсарлага | Ширхэг | 30,000 | 2 | 60,000 |
| | Печень | | | 10,000 | 10 | 100,000 |
| | Бялуу | | | 45,000 | 7 | 315,000 |
| | Нэг удаагийн аяга | | | 7000 | 2 | 14,000 |
| 8 | Илтгэгчийн хөлс | Н.Очирбат-Лектор | Цаг | 350,000 | 1:00 | 350,000 |
| 9 | Тэмцээний шагналын сан | Гар бөмбөг-Тэргүүн байр | Ширхэг | 400,000 | 1 | 1,330,000 |
| | | Гар бөмбөг-Дэд байр | Ширхэг | 300,000 | 1 | |
| | | Гар бөмбөг-Гутгаар байр | Ширхэг | 200,000 | 1 | |
| | | Ширээний теннис-Тэргүүн байр | Ширхэг | 150,000 | 1 | |
| | | Ширээний теннис-Дэд байр | Ширхэг | 100,000 | 1 | |
| | | Ширээний теннис-Гутгаар байр | Ширхэг | 80,000 | 1 | |
| | | Өргөмжлөл | Ширхэг | 50000 | 6 | 300,000 |
| Нийт | | | | | | 3,990,000 |

-оОо-